



"ГЛОБ ИНТЕРНЭШНЛ" ТББ

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН 2011



ЮНЕСКО-гийн Бээжин дэх
Төлөөлөгчийн газар



АНУ-ын Элчин Сайдын Яам



Нээлттэй Нийгэм Сан



Нээлттэй Нийгэм Форум

ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТАЙЛАН *2011*

2011 оны 5 сар - 2012 оны 5 сар

Энэ тайланг бэлтгэхэд дэмжлэг үзүүлсэн ивээн тэтгэгчдэдээ гүн талархал илэрхийлье.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага нь 1999 оны 3-р сард Улаанбаатар хотноо байгуулагдсан, нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй, ашгийн төлөө бус байгууллага юм.

Эрхэм зорилго

Мэдээлэл, мэдлэгийн хүчийг түгээж, Монгол улсад ардчилал, иргэний нийгмийг хөхиүлэн дэмжих

Алс хэтийн хараа

Ардчилсан соёл төлөвшсөн нийгэм, мэдээлэлтэй, чадавхитай иргэд

Үнэт зүйлс:

- Хараат бус
- Шударга ёс
- Ардчилсан
- Ялгаварлан гадуурхалтаас ангид
- Авлигагүй

Стратегийн зорилт, үндсэн хөтөлбөр

- Хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь
- Засаглал, ил тод байдлыг хөхиүлэн дэмжих нь
- Олон нийтийг чадавхжуулах нь



Мэдлэг бол - Хүч

Хаяг: Чингэлтэй дүүрэг, VI хороо,
Дипломат 95 цогцолбор, 6-р орц 70
тоот Улаанбаатар – 15141,
ш/х 102, Монгол улс

Утас: 976-11-324627,
976-11-324764

Факс: 976-11-315326

Э-шуудан: globenews@globeinter.org.mn,
globemon@gmail.com,
hnanan@globeinter.org.mn,

Веб: www.globeinter.org.mn

ГАРЧИГ

ӨМНӨТГӨЛ.....	4
НЭГ. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ	6
1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа	6
1.2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт	10
1.3. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт	19
ХОЁР. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ 2011 ОНД.....	20

ӨМНӨТГӨЛ

Бид Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний ээлжит тайлангаа та бүхэнд өргөн барьж байгаадаа баяртай байна. Энэ ялдамд тайлан бэлтгэх боломж олгосон Нээлттэй Нийгэм Форум (ННФ), Нээлттэй Нийгэм Сангийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөр, ЮНЕСКО-гийн Бээжин дэх Төлөөлөгчийн газар, Улаанбаатар дахь Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яаманд талархал илэрхийлье.

Хэвлэлийн хүрээлэнгийн судалгаагаар 2011 онд Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй 469 хэвлэл мэдээллийн хэрэгсэлд 4415 хүн ажилладгийн 1989 нь бүтээлч ажилтан (сэтгүүлч, сурвалжлагч, редактор, найруулагч г.м.) байна. Орон нутагт 155 хэвлэл мэдээллийн хэрэгсэл (нийт ХМХ-ийн 33%) үйл ажиллагаа явуулж байна. Улсын хэмжээнд гадаад хэл дээр 9 сонин, үндэстний цөөнх болох казах хэлээр 2 сонин уншигчдын гар дээр очдог.

2011 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг 30 цахим хуудас бүртгэгджээ. Хэвлэмэл болон цахим сонин 5, онлайн сонин 5, цахим хаягтай сонин 26 байна. Интернэтээр 5 радио сонсож 13 телевизийг шууд үзэх боломжтой. Мөн www.sonin.mn цахим хуудаснаас 24 сонин уншиж болно.

Хэвлэлийн эрх чөлөөний тайлан нь Монголын сэтгүүлчид мэргэжлийн эрхээ хэрхэн эдэлж буй, тэдний олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа шударгаар биелүүлэх боломж нь аль хэр байгааг баримтад тулгуурлан монголын хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн дүр төрхийг харуулах зорилготой юм.

2011 онд “Хил хязгааргүй сурвалжлагчид” (RSF) олон улсын байгууллагын үнэлж буйгаар Монгол Улс 100 дугаар байранд жагсаж, хэвлэлийн эрх чөлөөний “мэдэгдэхүйц асуудал”-тай орны тоонд багтсан хэвээр байна. Мөн “Фрийдом хаус” (Freedom House) байгууллагын индексээр Монгол Улс хэвлэлийн хагас эрх чөлөөтэй орон хэвээр байна.

2011 онд УИХ-аас “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль батлан гаргасан нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн хамгийн чухал алхам болсон юм. Харилцаа холбооны зохицуулах хорооноос өнгөрсөн хоёрдугаар сард баталсан “Тоон контентын үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага”, “Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага” гуравдугаар сараас хэрэгжүүлж эхэлсэн нь хэвлэл мэдээллийн эрх зүйн салбарт гарсан томоохон өөрчлөлт байв.

Мөн Монгол Улсын Засгийн газар 2011 оны 3 дугаар сард НҮБ-ын Хүний эрхийн хороонд “Иргэний болон Улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ын хэрэгжилтийн талаарх ээлжит 5 дахь илтгэлээ тавьж хэлэлцүүлсэн билээ. Уг Пактын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан 19 дүгээр зүйлийг хэрхэн хэрэгжүүлж байгаад НҮБ-ын Хүний эрхийн хорооны гишүүд үнэлэлт дүгнэлт өгч, нэр

төр гутаахтай холбоотой Эрүүгийн хуулийн зүйл заалтыг халах, сэтгүүлчдийн эсрэг хэргийг мөрдөж, шалгах талаар зөвлөмж гаргасан нь онцгой ач холбогдолтой юм.

2011 оны 9 дүгээр сард Азийн хүний эрх, хөгжлийн форум (FORUM-ASIA) байгууллагын төлөөлөгчид Монгол улсад ажиллаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар баримт цуглуулах судалгаа хийсэн нь өнгөрсөн жилийн тэмдэглүүштэй арга хэмжээний нэг байв. Судалгааны баг тайландаа: “Уулзаж ярилцсан сэтгүүлчид нь төрийн албан хаагчид, улс төрчид, бизнесменүүд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт шахалт үзүүлэн, сүрдүүлж, тэдний эсрэг хэрэг үүсгэдэг, бие эрхтэнд нь халддаг тухай ярилаа. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд редакцийн цензур, сэтгүүлчдэд өөрийн цензур бий болоход хүргэж байна. Ийм тохиолдол гарахад хууль сахиулах байгууллагууд арга хэмжээ авдаггүй, ихэнх хэргүүд үнэн зөвөөр шийдэгдэхгүй, буруутан гэм зэмгүй өнгөрч байгаад судалгааны багийнхан түгшиж байна” гэжээ.

2011 онд манай байгууллагын бүртгэснээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, дарамт шахалт үзүүлэх, сэтгүүлчдийг айлгах, утсаар заналхийлэх, айлгах, мэдээлэл олж авах, түгээхэд нь саад хийх, нууц эх сурвалжаа илчлэхийг албадах, улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, бизнес, шашны байгууллагууд Иргэний болон Эрүүгийн хуулийн зүйл заалтыг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн дуу хоолойг боомилох зорилгоор ашиглах зэрэг зөрчил гарсан байна.

2012 оны “Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдөр”-ийг тэмдэглэж буй энэ цаг мөчид бид өнгөрсөн жил “Улаанбаатар таймс” сонины эрхлэгч Д.Чулуунбаатарыг цагдан хорьсон нь дэлхий нийтэд хэвлэлийн эрх чөлөөний индекс буурахад нөлөөлсөн, улс төрийн зорилго бүхий, ардчилсан нийгэмд хүлээн зөвшөөрөхийн аргагүй үйлдэл байсныг цохон тэмдэглэж байна.

Та бүхэнд толилуулж буй уг тайлангийн эхний бүлэгт бид үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрх зүйн хүрээ, тухайлбал баталгаа, хязгаарлалтын талаар танилцуулж, хоёр дахь бүлэгт 2012 онд хэвлэлийн эрх чөлөөний чиглэлээр онцлох мэдээллийг багтаасан болно.

**“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын тэргүүн
Х.Наранжаргал**

НЭГ. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЗҮЙН ХҮРЭЭ

1.1. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Үндсэн хууль

Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлд Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ хэмээн заасан юм.

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

Олон улсын хууль тогтоомж

Монгол Улс НҮБ-ын гишүүн орны хувьд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн, мөн 1974 онд “Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын Пакт”-д нэгдэн орсон. Иймд Монгол Улс дээрх хоёр бичиг баримтын 19 дүгээр зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг олон улсын эрх зүйн дагуу хамгаалах үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд зааснаар дээрх зүйл заалт дотоодын хууль адил хүчин төгөлдөр байна.

2011 оны 7 дугаар сарын 11-29-ний өдрүүдэд Женев хотноо болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 102 дугаар чуулганаар Үзэл бодол, үзэл бодлыг илэрхийлэх эрх чөлөөг баталгаажуулсан Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 19 дүгээр зүйлд 34 тоот ерөнхий тайлбарыг баталсан байна.

Үндэсний хууль тогтоомж

2002 оны 5 дугаар сарын 30-ны өдөр батлагдсан “Зар сурталчилгааны тухай” хуулийн 3 дугаар бүлэгт “мэдээлэх хэрэгсэл” гэсэн тодорхойлолт байдаг ба үүнийг Улсын Дээд шүүх тайлбар гаргахдаа үндэс болгодог.

Зүйл 3.1

Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.5 “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно.

Зар сурталчилгааны тухай хуулиас

Мэдээллийн эрх чөлөө

Монгол Улсын Их Хурал 2011 оны 6 дугаар сарын 16-нд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль баталсан нь 2011 оны 12 дугаар сарын 1-нээс бүрэн хэрэгжиж эхэлсэн юм. Энэ нь иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг бодитой болгох, ил тод, сайн засаглалыг бэхжүүлэх, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахад чухал ач холбогдол бүхий алхам болсон юм. Уг хуулиар үйл ажиллагаа, төсөв, санхүү, төрийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах мэдээллээ нээлттэй байлгах үүргийг төрийн байгууллагуудад ногдуулж, иргэн, хуулийн этгээд төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхийг баталгаажуулсан юм.

Харамсалтай нь, хуулийн сурталчилгаа, хэрэгжилт хангалтгүй байна. Монголын Засгийн газар үйлчилгээний хөлс тооцох аргачлал, үйлчилгээний хөлс төлөх, түүнээс хөнгөлөх, чөлөөлөх журмыг өнөө хэр баталж гаргаагүй байна. Сэтгүүлчид ч энэ хуулийг төдийлөн үр дүнтэй ашиглаж чадахгүй байна.

Хэвлэлийн эрх чөлөө ба сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагаа

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль баталсан юм. Хуулийн 2 дугаар зүйлээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон юм. Мөн 3 дугаар зүйлээр “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан ба 4 дүгээр зүйлээр “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэжээ.

УИХ-аас 2005 оны 1 дүгээр сарын 27-нд “Олон нийтийн радио, телевизийн тухай” хууль баталсан нь хэвлэлийн эрх чөлөөг хэрэгжүүлэх чиглэлээр хийсэн чухал ач холбогдол бүхий алхам байлаа. Хууль 2005 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болж, төрийн мэдлийн байсан Монголын үндэсний радио, телевизийн хэрэг эрхлэх газар татан буугдсан билээ. Түүний оронд Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз (МҮОНРТ) байгуулагдан 2006 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

“Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийг шинэчлэн найруулах тухай яригдаад хоёр жил гаруй болж байна. Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын боловсруулсан хуулийн шинэчилсэн найруулгын хоёр төслийг УИХ-д өргөн мэдүүлснийг УИХ-ын чуулганы 2012 оны нэгдүгээр сарын 19-ний өдрийн үдээс хойшхи хуралдаанаар Засгийн газар, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өргөн мэдүүлсэн “Хэвлэлийн эрх чөлөөний тухай шинэчилсэн хуулийн хоёр төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал

хурааж, чуулганы хуралдаанд оролцсон гишүүдийн 74.9 хувь нь хэлэлцэх нь зүйтэй гэж үзжээ. Гэсэн ч УИХ төслүүдийг хэлэлцээгүй байна.

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлээр сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийх нь гэмт хэрэг гэж үзсэн юм.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Хэвлэлийн эрх чөлөөний тухай” шинэчилсэн хуулийн төсөлд “хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлч олж авсан мэдээллийн эх сурвалжаа илчлэхгүй байхыг үүрэг болгосон” байна. Засгийн газрын төсөлд “энэ хуульд зааснаас бусад тохиолдолд мэдээ, мэдээллийн эх сурвалжийг нууцлах эрхтэй” гэж тусгагджээ.

Сонгууль ба хэвлэл мэдээлэл

2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдсан. Энэ хуулийн “Сонгуулийн сурталчилгаа” хэмээх 35 дугаар зүйлд хэвлэл мэдээллээр сонгуулийн аян явуулахтай холбоотой шинэ зохицуулалт оржээ. Тухайлбал:

- 35.4. Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан хорин хэвлэлийн хуудас бүхий сонин, хэвлэл, арван хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг арван хэвлэлийн хуудаст тус тус багтаана.
- 35.5. Бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө танилцуулсан тус бүр хоёр хэвлэлийн хуудас бүхий хоёр сонин, хэвлэл, нэг хэвлэлийн хуудас бүхий нэг ухуулах болон зурагт хуудас, нэр дэвшигчийн намтар, бусад сурталчилгааны материалыг нэг хэвлэлийн хуудаст тус тус багтаана.
- 35.11. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевизээр сурталчилгааны нэвтрүүлгийг төлбөртэй нэвтрүүлж болох бөгөөд сурталчилгааны төлбөртэй нэвтрүүлгийн нийт хугацаа нь хоногт хоёр цагаас илүүгүй байна.
- 35.12. Олон нийтийн радио, телевизээс бусад радио, телевиз нь нэгээс илүү сувагтай бол сурталчилгааны нэвтрүүлгийг зөвхөн агаарын долгион ашигладаг үндсэн сувгаар нэвтрүүлнэ.
- 35.13. Сонгуулийн ерөнхий хороо болон Харилцаа холбооны зохицуулах хороо энэ хуулийн 35.11-д заасан радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг нэвтрүүлэх журмыг хамтран баталж, түүний хэрэгжилтэд хяналт тавина.

Энэ хуулийн 9.4-д “Хэвлэл мэдээллийн байгууллага, түүний албан тушаалтан сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн зөв, бодитой мэдээлэл түгээх үүрэгтэй”-г заасан бөгөөд үүнийг зөрчсөн хэвлэл мэдээллийн байгууллагыг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг¹ 15-20 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, албан тушаалтныг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёроос гурав дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тус тус торгохоор өөрчилсөн байна. Өмнөх хуультай харьцуулбал хэвлэл мэдээллийн байгууллагын торгуулийн хэмжээг 3.5 дахин нэмэгдүүлжээ.

¹ 2011 оны 4-р сарын 5-ны өдрөөс 140.400 төгрөг болсон.

Сонгуулийн ерөнхий хороо 2012 оны 4 дүгээр сарын 06-ны өдөр “Монгол Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах, сурвалжлах тухай” журам батлах тухай 25 дугаар тогтоол баталжээ. Уг журмын “Хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч сонгуулийн явцыг сурвалжлах” гэсэн 6 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч нь сонгуулийн явцыг сурвалжлахдаа баримт нотолгоо, үнэн зөв мэдээлэлд тулгуурлан хараат бус, шударга, хууль дээдлэх зарчимд тулгуурлан, сэтгүүлчийн ёс зүйг баримтлана” гэсэн байна. 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Сонгуулийн хороод сурвалжлагч нарыг дараахь боломжоор хангана” гэжээ. Үүнд:

- 6.2.1. сонгуулийн бэлтгэл ажлын явцын талаар мэдээлэл авах;
- 6.2.2. хороодын ажлын зохион байгуулалт, үйл ажиллагаатай танилцах;
- 6.2.3. санал авах ажлын зохион байгуулалттай холбоотой мэдээ, мэдээлэл авах;
- 6.2.4. зөөврийн битүүмжилсэн хайрцгаар сонгогчийн саналыг авах явцын талаар мэдээлэл авах, сурвалжлага хийх;
- 6.2.5. санал хураах явц, санал тооллогын дүн гаргах, мэдээлэх зэрэг ажиллагаатай холбогдсон мэдээ, сурвалжлага авах.

Журмын 6.3-д сурвалжлагчдад дор дурдсан үүрэг ногдуулсан байна. Үүнд:

- 6.3.1. Монгол Улсын Үндсэн хууль болон сонгуулийн тухай хууль тогтоомжийг хүндэтгэн сахих;
- 6.3.2. сонгуулийн хороодын үйл ажиллагаанд хутгалдан оролцохгүй байх;
- 6.3.3. саналаа нууцаар гаргаж буй сонгогчийн эрхийг хүндэтгэх, тэдэнд саад учруулахгүй байх;
- 6.3.4. санал тоолох, дүн гаргах ажиллагаанд саад учруулахгүй байх;
- 6.3.5. санал авах өдөр нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсвэл эсэргүүцсэн хувцас өмсөх, сурталчилгааны зүйл авч явахгүй байх;
- 6.3.6. санал авах байрны дэг журмыг сахих, сонгуулийн хорооны гишүүд, сонгогчидтой зөв боловсон харьцах;
- 6.3.7. сонгуулийн хороодын болон сонгуулийн үйл ажиллагааны талаар үнэн бодит мэдээллийг шуурхай түгээх.

Журмын 6.4-д “Сурвалжлагч нь зураг бүхий, ажлын газрын хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх ба тухайн хэвлэл мэдээллийн байгууллагын таних тэмдэг бүхий хувцас, техник хэрэгсэлтэй байна” гэжээ.

“Гадаадын хэвлэл мэдээллийн байгууллагын сурвалжлагч нар Улсын Их Хурлын сонгуулийг ажиглах хүсэлтээ Гадаад харилцааны яамаар дамжуулан Сонгуулийн ерөнхий хороонд уламжилна” хэмээн журмын 6.5-д заажээ.

Журмын 7.1-д “Сонгуулийн үйл явцыг ажиглаж, сурвалжилж буй ажиглагч, сурвалжлагчдад дараах зүйлийг хориглосон байна. Үүнд:

- 7.1.1. сонгогчийн өмнөөс сонгогчдын нэрийн жагсаалтад гарын үсгээ зурах;
- 7.1.2. санал бэлтгэх бүхээгт сонгогчтой хамт байх;
- 7.1.3. сонгогчийн хүсэлтээр болон өөрийн санаачлагаар түүний өмнөөс санал өгөх;

- 7.1.4. сонгогчтой сонголтынх нь талаар асууж, ярилцах;
- 7.1.5. сонгуулийн үйл ажиллагааг ажиглах, сурвалжлах үедээ нам, эвсэл, нэр дэвшигчийг дэмжсэн, эсхүл эсэргүүцсэн утга илэрхийлсэн хувцас, эд хэрэглэл өмсөх, хэрэглэх, ийм төрлийн сурталчилгааны зүйлс биедээ авч явахгүй байх;
- 7.1.6. сонгогчдод болон сонгуулийн хорооны гишүүдэд хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх, худал хуурамч мэдээлэл олон нийтэд тараах зэрэг хууль бус арга хэрэглэх;
- 7.1.7. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль болон энэ журамд заагаагүй эрх эдлүүлэхийг шаардах.

2006 оны 1 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан “Сонгуулийн төв байгууллагын тухай” хуулийн 14 дүгээр зүйлд сонгуулийн үеэр Хэвлэл мэдээллийн зөвлөл ажиллахаар зохицуулсан бөгөөд 14 дүгээр зүйлийн хоёр дахь хэсэгт “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь хэвлэл, мэдээллийн мэргэжлийн байгууллага, төрийн бус байгууллагын төлөөлөл болон сонгуульд оролцож буй нам, эвслийн тэгш төлөөллөөс бүрдсэн байна” гээд 14.3-д “Хэвлэл мэдээллийн зөвлөл нь нам, эвсэл, нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн сурталчилгааны тэнцвэрт байдалд хяналт тавих бөгөөд энэ асуудлаар нам, эвсэл, нэр дэвшигч, хуулийн этгээд, иргэнээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан үзэж, санал дүгнэлт гаргаж Хороонд танилцуулах чиг үүргийг заасан байна.

Сэтгүүлчийн нууц эх сурвалж

Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах тухай хууль Монгол улсад байхгүй. 2005 оны 3 дугаар сарын 11-ний өдөр хуралдсан МСНЭ-ийн 2 дугаар их хурлаар баталсан “Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим”-аар үүнийг хүлээн зөвшөөрсөн боловч шүүхийн практикт ашиглагддаггүй.

Дөрөв. Хүний итгэлийг хүлээж олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцална.

“Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим”-аас

1.2. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт

Мэдээлэл олж авах эрхийн хязгаарлалт

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль батлагдсан ч нууцын хуулиудад нэмэлт өөрчлөлт ороогүй байна. Монгол улсад төрийн нууцыг “Төрийн нууцын тухай” хууль, “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулиар хамгаалдаг. “Төрийн нууцын тухай хууль” 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1 дүгээр сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. “Төрийн нууцын тухай” хуульд: “Төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томьёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник-технологийн шийдэл болон үйл

ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ” гэж тодорхойлсон байдаг.

Хуулийн 11 дүгээр зүйлд зааснаар “Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно” гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

“Төрийн нууцын тухай” хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг. Мөн “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулиар 59 зүйлийн мэдээллийг, тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 6 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт 59 зүйлээр тогтоосон мэдээллийн 69.5 хувийг 40-60 жилээр, эсвэл байнга нууцалсан байна.

Нууцалсан зэрэглэлээр үзвэл онц чухал-маш нууц мэдээлэл 6, маш нууц мэдээлэл 24, нууц мэдээлэл 7 байна. “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулинд шууд зааж өгөөгүй, нууцалсан зэрэглэлээр гэж ангилсан 25 мэдээлэл байгаа юм.

2004 оны 4 дүгээр сарын 23-нд нэмэлт оруулсан “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуульд “Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичгийг бүхэлд нь нууцалсан зэрэглэлээр, байнга”-ын хугацаагаар нууцлах ажээ.

Эрүүгийн хуулийн 87.1 дүгээр зүйлд “төрийн нууц задруулах” гэмт хэргийг зааж өгсөн байдаг. Үүнд “Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”, 87.2 дугаар зүйлд “Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ” гэж заасан байдаг.

“Байгууллагын нууцын тухай” хууль нь нууцын дэглэмийг байгууллагад хамруулсан. 1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан энэ хуульд байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/. Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөөлрүүлэх оролдлого хийж нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан. Үүнд, тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийтэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Эрүүгийн хуулийн 164 дүгээр зүйлээр санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулбал торгохоос эхлэн гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан. Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол дээд тал нь гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх юм байна.

Эрүүгийн хуулийн 136.1-д зааснаар “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”.

Нэр төр гутаахтай холбоотой хууль тогтоомж

2002 оны Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлээр иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан байна.

2002 оны 9 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлээр доромжлол, гүтгэлгийг гэмт хэрэг гэж үздэг. Энэ зүйл заалтаар нэгээс зургаан сар баривчлах ял ногдуулж болно.

Эрүүгийн хуулийн эдгээр зүйлд Улсын Дээд шүүхээс 2007 оны 10 дугаар сарын 29-нд тайлбар гаргаж, нэр төр, алдар хүнд, доромжлох, гутаах зорилго, худал гүжирдлэг, олон нийт, урьд ял шийтгүүлсэн гэх мэт дээрх зүйлд дурдагдсан нэр томьёог тайлбарлажээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага энэ тайлбарыг дэвшилттэй гэж үздэггүй бөгөөд манай хуульч дараах дүгнэлт хийсэн. Үүнд: “нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтыг олон улсын жишигт тохирохгүй, гүтгэх, доромжлох хэргүүдийг хэлбэрийн бүрэлдэхүүнтэй хэрэг гэдэг нь тийм ч зөв тайлбар биш, ялангуяа “гүтгэх гэмт хэрэг дээр хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэж тайлбарласан нь гүтгэсэн гэж үзэж байгаа мэдээлэл үнэн бодит байдалд нийцэхгүй, худлаа мэдээлэл юм гэдэг нь тогтоогдвол шууд л гэмт хэрэг үйлдсэн байна гэж ойлгохоор болсон байна” гэж үзэж байгаа юм.

Монгол улсын Засгийн газрын “Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт”-ын хэрэгжилтийн талаарх тайлан илтгэлийг 2011 оны 3 дугаар сарын 14-нөөс 21-нд АНУ-ын Нью-Йорк хотод болсон НҮБ-ын Хүний эрхийн хорооны 101 дүгээр хуралдаанаар хэлэлцсэн юм. Хүний эрхийн хорооноос Монгол улсын Засгийн газарт хандан дараах зөвлөмжийг өгчээ.

Нэр төр, алдар хүндэд халдсан хэргийг эрүүгийн гэмт хэргээс хасч, сэтгүүлчийг аливаа сүрдүүлэг заналхийлэл, халдлагаас хамгаалахад шаардлагатай арга хэмжээ авах

Сүрдүүлэг заналхийлэл, халдлагын аливаа тохиолдлыг хуулийн дагуу мөрдөн шалгаж, гэмтэнд хариуцлага хүлээлгэхэд Оролцогч улс анхаарах

Гэвч Эрүүгийн хуулийн нэр төр гутаахтай холбоотой зүйл заалтыг халах чиглэлээр Засгийн газраас дорвитой алхам хийгээгүй байна.

Монгол улсын Засгийн газарт хандан өгсөн зөвлөмжийг үндэслэн “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 2011 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалангаар уламжлан Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах Ажлын хэсэгт албан захидал илгээсэн болно.

Азийн хүний эрх, хөгжлийн форум (FORUM-ASIA)-ын судалгааны багийнхан Монгол улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх, эрх чөлөөний

байдалд хийсэн баримт цуглуулах судалгааны урьдчилсан дүнгээ 2011 оны 9-р сарын 2-нд Улаанбаатар хотноо хэвлэлийн бага хурал зохион байгуулж танилцуулсан юм.



“Баримт цуглуулах судалгааны багийнхан сэтгүүлчдийн эсрэг гүтгэлэг, доромжлолтой холбоотой хэргүүд, ялангуяа эрүүгийн хэрэг өсөх хандлагатай байгаад түгшиж байна.

Ардчилсан нийгэмд төрийн өндөр албан тушаалтнууд нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг ба түмний хараа хяналт, шүүмжлэлд өртөмтгий бүлэгт багтдаг юм. Төрийн алба хашиж байгаагийн хувьд шүүмжлэлд өртсөн бол тэд гомдол гаргах ёсгүй байдаг.

Гүтгэлэг, доромжлолын хэргийг шийдвэрлэх олон арга байдаг. Үүнд: эвлэрэх, залруулга нийтлэх, олон нийтийн өмнө уучлал хүсэх, иргэний хэргээр шийдвэрлэх гэх мэт. Хэвлэл мэдээлэл нь нийгмийн “хоточ нохой” бөгөөд хэвлэлийн эрх чөлөө бол эрүүл саруул ардчилсан нийгмийн тулгын чулуу юм. Иймээс, гүтгэлэг доромжлолын заалтыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүйн тулд эрүүгийн хуулиар шийдэхгүй байх шаардлагатай гэж мэдэгдсэн юм.

(Судалгааны багийн урьдчилсан тайланг Хавсралт 1-ээс үзнэ үү)

“Хэвлэлийн эрх чөлөөний тухай” хуулийн төслийг шинэчлэн найруулж байгаатай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар Нээлттэй нийгэм форумтай хамтран “Хүний нэр төр, алдар хүндийн эрх зүйн хамгаалалт” сэдвээр “Иргэний танхим”-д 2011 оны 10-р сарын 16-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт хууль, шүүх, өмгөөллийн болон хэвлэл мэдээлэл, төрийн бус байгууллагуудын төлөөлөл, хууль зүйн сургуулийн багш, судлаачид оролцсоноос дийлэнх нь Эрүүгийн хуулийн 110,111 дүгээр зүйлийг хасч, иргэний хуульд эл асуудлыг илүү тодорхой зүйлчлэн тусгаж шийдэж байх нь зүйтэй гэж үзсэн байна.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэ асуудалд онцгой анхаарч, өдөр тутмын “Өдрийн сонин”-ы эхлүүлсэн хэлэлцүүлгийг “Өглөөний сонин”, “Зууны мэдээ”, “Монголын мэдээ” зэрэг өдөр тутмын бусад сонин дэмжиж, Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой зүйл заалтыг халахад хувь нэмэр оруулсан улс төрчдийг дэмжихээ илэрхийлжээ.

Агуулгын хязгаарлалт

Монгол улсын олон хууль тогтоомжоор хэвлэл мэдээллийн агуулгад хязгаарлалт тавьсан байдаг. Тухайлбал:

- “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 1.6-ийн дагуу хүүхдийн хүмүүжил, ёс суртахуунд сөрөг нөлөө үзүүлсэн;
- “Хүүхдийн эрхийг хамгаалах тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 5-д заасан зүйлсийг илэрхийлсэн;
- “Садар самуун явдалтай тэмцэх тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.2, 7 дугаар зүйлийн 7.2.3, Эрүүгийн хуулийн 123 дугаар зүйлд заасан эротик төрлийн контентыг агуулсан, садар самууныг илэрхийлсэн;
- “Архидан согтуурахтай тэмцэх тухай” хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-д заасан согтууруулах ундаа сурталчилсан;
- “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай” хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4-д заасан зүйлсийг сурталчилсан, илэрхийлсэн;
- Эрүүгийн хуулийн 86 дугаар зүйлд заасан үндэсний эв нэгдлийг бусниулах чиглэлээр сурталчилгаа явуулсан;
- Эрүүгийн хуулийн 1783 дугаар зүйлд заасан терроризмийг сурталчилсан;
- Эрүүгийн хуулийн 179 дугаар зүйлд заасан нийтийн эмх замбараагүй байдалд өдөөн турхирсан;
- Эрүүгийн хуулийн 144 дүгээр зүйлд заасан шашны харгис үзэл номлолыг сурталчилсан;
- “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай” хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-д заасан зүйлсийг илэрхийлсэн;

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар баталсан “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хууль батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр болжээ. Энэ хуулиар хэвлэл, мэдээллийн байгууллагад хүн худалдаалахтай холбоотой зар сурталчилгаа, мэдээлэл тараахыг хориглосон үүрэг оногдуулж, зөрчсөн тохиолдолд хэвлэл, мэдээллийн байгууллагыг 5 сая төгрөгөөр торгох заалт орсон байна.

Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг шийтгэж болзошгүй зарим заалтыг энд дурдав.

Эдгээр хязгаарлалт нь нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хийгдсэнийг бид хүлээн зөвшөөрч байгаа боловч нэр томьёоны хувьд ерөнхий, тодорхойлолт байхгүй нь хэтрүүлэн ашиглах нөхцөл үүсгэж болзошгүйг шүүмжилдэг.

Учир нь Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг шийтгэх боломж байдаг. Тухайлбал, садар

самууныг сурталчилсан (123-р зүйл), иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн (135-р зүйл), шашны харгис үзэл номлолыг санаатай сурталчилсан буюу тараасан бол (144.1-р зүйл), хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол (257.1-р зүйл) торгох, нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах хүртэл ял шийтгэх ажээ.

Эрүүгийн хуулийн 231 дүгээр зүйлд зааснаар төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагч нарыг доромжлох нь нэгээс гурван сар хүртэл баривчлах ял шийтгүүлэх гэмт хэрэг байдаг. Уг хуульд тайлбарласнаар “Төрийн

албан хаагч” гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гааль, татварын албаны байцаагч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно” гэжээ. Энэ нь төрийн албан хаагчдыг шүүмжилсэн сэтгүүлчдэд халгаатай зүйл заалт юм.

Монгол улсад урьд өмнө нь хэвлэл мэдээллийн агуулгыг зохицуулагч байсангүй. Харилцаа холбооны зохицуулах хорооны (ХХЗХ) 2011 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”, “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ыг баталж, 2011 оны 03 дугаар сарын 01-ээс хэрэгжүүлж эхэлсэнээр ХХЗХ нь агуулгын зохицуулалтын эрх мэдэлтэй болжээ. Одоогоор сонин хэвлэлийн агуулгыг зохицуулагч үгүй байна.

Эдгээр шинэ зохицуулалтаар агуулгад тавигдах шаардлагыг тодорхойлж, дээр дурдсан хуулийн зүйл заалтыг жагсаасан байна. Радио, телевизийн хувьд “нийтийн эрх ашгийг” дээдлэх (5.1) үүрэг ногдуулж, долоо хоногийн хөтөлбөрийн нийт цагийн 50-иас доошгүй хувь нь Монгол Улсад бүтээгдсэн эсхүл Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн бүтээсэн нэвтрүүлэг” (5.4) байхаар заажээ.

“Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын дагуу 2011 оны 3 дугаар сараас эхлэн сар бүр эфирийн 14 телевизийн дотоод контент, чат, мессеж ашигласан нэвтрүүлэг, зар сурталчилгааны хэтэрсэн хугацаа болон телевизийн хөтөлбөр, цагийн хуваарьт мониторинг хийж дүнг вэб хуудсаараа дамжуулан олон нийтэд мэдээлж байна. ХХЗХ 2011 оны эхний 11 сард хийсэн мониторингийн дүнд үндэслэн нөхцөл шаардлагыг зөрчсөн гэх эфирийн 12 телевизэд дахин сануулга хүргүүлжээ ².

Харилцаа холбооны зохицуулах хороо байнгын мониторинг, хяналт тавих тогтолцоог бий болгож нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд зөрчлөөс хамааруулан тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу радио, телевиз, олон суваг дамжуулах үйлчилгээ, контентын үйлчилгээ эрхлэгчдийн тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох эрхийг ХХЗХ эдэлж байгаа нь өргөн нэвтрүүлгийн хэрэгсэлд тавих цензур болон хувирч болзошгүй хэмээн “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага болгоомжилж байгаа юм.

“Радио, телевизийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага”-тай хамт баталсан “Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага” мөн 2011 оны 3 дугаар сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэн. Энэ нь харилцаа холбооны үйлчилгээ эрхлэгч, контентын агрегатор, контент нийлүүлэгч, вэб сайтын үйлчилгээ эрхлэгч, контент хостингийн үйлчилгээ эрхлэгч нар контентын үйлчилгээтэй холбогдсон харилцааг зохицуулж байна.

“Тоон контентын үйлчилгээний зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын дагуу вэб сайтын хэрэглэгчийн дундаж хандалт нэг сарын хугацаанд өдөрт 3000-аас давсан 15 вэб сайт Харилцаа холбооны зохицуулах хороонд бүртгүүлжээ.

НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага (OSCE)-ын хэвлэл мэдээллийн эрх чөлөөний төлөөлөгч болон Америкийн муж улсуудын байгууллага (OAS)-ын үзэл бодлын эрх

² <http://www.crc.gov.mn/>

чөлөөний тусгай илтгэгч нарын 2005 оны 12 дугаар сарын 21-ний өдөр баталсан Хамтарсан Тунхаглалд “Интернэт үйлчилгээний нийлүүлэлт, цахим хуудас, блог буюу мэдээлэл түгээлтийн онлайн систем, түүнчлэн интернэт өргөн нэвтрүүлэг ажиллуулахын тулд бүртгүүлэх, төрийн аливаа байгууллагаас зөвшөөрөл авах ёсгүй. Энэ нь зөвхөн техникийн зориулалтаар домэйн нэрийн эрхийн бүртгэл, эсвэл арилжааны аливаа хэлбэрт хамааралтай ерөнхий хэрэглээний дүрэм журамд хамаарахгүй” гэсэн билээ.

Бүртгүүлсэн вэб сайтуудад хэрэглэгч контент үүсгэх боломжтой, хэрэглэгчийн сэтгэгдэл үлдээх хэсэгтэй бол дараахь зохицуулалтыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ. Үүнд:

- Зохицуулах хорооноос ажиллуулж байгаа үгийн шүүлтүүр программ www.happywebs.mn заавал ашиглах;
- Монгол улсын холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлчилгээг ашиглахыг сануулсан нөхцөл шаардлагыг зөвшөөрсөн хэрэглэгчийг контент үүсгэх боломжоор хангах;
- Хэрэглэгч аль нэг өөр хэрэглэгчийн үүсгэсэн контентыг хууль бус, нийтийн ёс зүйд сөрөг нөлөөтэй гэж үзвэл саналаа илэрхийлэх, саналын тооноос хамааран тухайн контентыг арилгах боломжийг бүрдүүлэх;
- Хэрэглэгчийн интернэт хаягийг (IP address) хэрэглэгчийн үүсгэсэн контентын дээр нийтэд харагдахуйц байрлуулах;

Энэ ерөнхий нөхцөл шаардлагыг зөрчсөн тохиолдолд Зохицуулах хороо зөрчлөөс хамааруулан хугацаатай үүрэг даалгавар, шаардлага өгөх; захиргааны хариуцлага хүлээлгэх арга хэмжээ авахуулахаар холбогдох хяналтын байгууллагад мэдэгдэх; тусгай зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх, хүчингүй болгох тухай сануулах; түдгэлзүүлэх; тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгох зэрэг тусгай зөвшөөрлийн гэрээнд заасан эдийн засгийн хариуцлага хүлээлгэх эсхүл холбогдох хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээг авна. Зохицуулах хороо байнгын мониторинг хийх, хяналт тавих тогтолцоо бий болгож, Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, Оюуны өмчийн газар, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, цагдаа, шүүх, тагнуулын байгууллага, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар зэрэг хуульд заасан эрх бүхий хяналтын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.

Зохицуулах хорооны 2012 оны 6 дугаар тогтоолоор “Харилцаа холбооны зохицуулах хорооноос гомдол, маргааныг хүлээн авах, хянах, шийдвэрлэх журам”-ыг шинэчлэн мөрдөж эхэлсэн байна.

Бусад зохицуулалт

Хэвлэл мэдээллийн өмчлөл ба төвлөрөл

Хэвлэл мэдээллийн өмчлөл нууц байх, хэвлэл мэдээлэл нэг гарт төвлөрөх нь редакцийн цензурыг өөгшүүлж, ингэснээр хэвлэлийн эрх чөлөөг боогдуулан, олон ургальч үзлийг сааруулж, сэтгүүл зүйн мэдээллийн чанарт сөргөөр нөлөөлдөг. Иймд дэлхий дахинд өмчлөлийн ил тод байдлыг хангах, төвлөрлийг хязгаарлах чиглэлээр эрх зүйн зохицуулалт хийж байна. Манайд ч мөн энэ чиглэлээр анхны алхам хийгдсэн нь сайшаалтай.

2010 онд батлагдсан “Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-д “Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшил, харьяалал нь ил тод байх” заалт анх удаа тусгагдсан юм.

“Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын “Эзэмшлийн ил тод байдал” 4 дүгээр бүлэгт “Эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эзэмшлийн хувь хэмжээ, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн нэр, дэлгэрэнгүй хаяг, харилцах утас, хуулийн этгээдийн удирдлага зохион байгуулалтын бүтэц, удирдах ажилтнуудын иргэншлийн тухай мэдээллийг жил бүр Зохицуулах хороонд мэдээлж байх” үүргийг радио, телевизийн сувгуудад үүрэг болгосон юм. Мөн гадаадын аль нэг улсын телевизийн сувгийн тоо нь нийт гадаадын сувгийн 30 хувиас хэтрэхгүй (9.6) байхаар зохицуулжээ.

Харилцаа холбооны зохицуулах хороо “Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага”-ын 4.3-д заасныг хэрэгжүүлж, эхний ээлжинд Улаанбаатар хотын телевиз, радио, олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн (KaTV, АйПиТВ, Мобайл ТВ) эзэмшигчдийн талаарх мэдээллийг олон нийтэд зарласан байна. Үүнд Улаанбаатар хотод телевизийн үйлчилгээ эрхлэгч 17 суваг, радиогийн үйлчилгээ эрхлэгч 22, телевизийн олон суваг дамжуулах 15 үйлчилгээ эрхлэгч хамрагдаж тэдгээрийн үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагч, харьяалал, захирлын нэрийг ил тод болгосон байна ³.

Дээрх нөхцөл, шаардлагын 3.9-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тусгай зөвшөөрлөөр олгогдсон эрх, үүрэг, хариуцлага, үндсэн үйл ажиллагаа, удирдлага, хөтөлбөртэй холбоотой харилцаагаа бусдад шилжүүлэхийг хориглоно” гэсний дагуу Америкийн 100 хувийн хөрөнгө оруулалт бүхий Ийгл телевиз Бодь группын мэдэлд шилжсэн нь 2012 онд хэвлэл мэдээллийн салбарт гарсан том өөрчлөлт байлаа.

Монголд хэвлэл мэдээллийн төвлөрлийн үйл явц гүнзгийрэх төлөвтэй байна. “Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай” хуулийн зүйл заалт хэвлэл мэдээлэлд хамаарах боловч одоогоор тухайн хуулийг ашиглаж буй тохиолдол бараг байхгүй. Харин нөхцөл шаардлагад 9.8-д “Тухайн зах зээлд давамгайлалгаар тодорхойлогдсон тохиолдолд харилцаа холбооны салбарын өрсөлдөөний зохицуулалттай холбогдох журмыг дагаж, мөрдөхөөр заажээ.

Зар сурталчилгаа

“Зар сурталчилгааны тухай” хуулиар хууль бус зар сурталчилгааг хориглодог. “Радио, телевизийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага”-аар анх удаа өргөн нэвтрүүлгийн хэрэгслээр дамжуулах зар сурталчилгаанд хязгаарлалт тавьсан юм. Тухайлбал:

- Нэг цаг тутамд дамжуулах зар сурталчилгаа нь арван таван минутаас хэтрэхгүй байна (6.4)
- Зар сурталчилгааны эхлэл болон төгсгөлийг үзэгчдэд ойлгомжтой байдлаар илэрхийлнэ (6.5)

³ http://www.crc.gov.mn/index.php?option=com_content&view=article&id=254:2012-02-20-01-16-05&catid=74:2011-05-16-03-23-40&Itemid=222

Өргөн нэвтрүүлэг

Монголд өргөн нэвтрүүлгийн бие даасан хууль байдаггүй. Гэхдээ долгион, тусгай зөвшөөрөлтэй холбоотой харилцааг “Долгионы тухай” хууль, “Харилцаа холбооны тухай” хуулиар зохицуулдаг. Хуулиар долгион бол ард түмний өмч юм.

Мэдээлэл, Шуудан, Харилцаа холбоо, технологийн газраас 2011 онд “Өргөн нэвтрүүлгийн тухай” хуулийн төсөл боловсруулж, санал авч байна. ХХЗХ-ны баталсан “Радио, телевизийн үйлчилгээ эрхлэх нөхцөл, шаардлага”, түүнийг дагалдан гарсан хэд хэдэн журамд өргөн нэвтрүүлгийн зохицуулалт бий.

Харилцаа холбооны зохицуулах хорооны “Телевиз, радиогийн үйлчилгээ эрхлэх ерөнхий нөхцөл, шаардлага”-ын дагуу кабелийн сувгаар өргөн нэвтрүүлэг эрхлэгчдэд өргөн нэвтрүүлгийн тусгай зөвшөөрөл олгох зохицуулалт орсон юм. Урьд өмнө нь эдгээр телевиз зөвхөн кабелийн сувагтай байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаа эрхэлж байв.

Тусгай зөвшөөрөл олгох өргөдлөө хугацаанд нь өгөөгүй шалтгаанаар хэд хэдэн сувгийг түр зогсоосон байна.

2011 оны 5 дугаар сарын 1-ний өдөр “Одод” спортын төрөлжсөн телевиз “Суваг түрээслүүлэгч байгууллага болох “Сансар” КАТВ ямар нэгэн шалтгаангүйгээр, урьдчилан мэдэгдэлгүй тус телевизийн сувгийг гэнэт тасалсан” тухай манай байгууллагад хандсан юм.

“Одод” телевизийнхэн энэ үйлдлийг “Эфирийн хэвийн үйл ажиллагааг зогсоож, гэрээний заалтуудаа зөрчин, нэр хүндэд нь халдсан” гэж үзэж “Сансар” КАТВ-ийн удирдлагуудад тайлбар хүссэн албан бичиг явуулжээ. Тус КАТВ-ийн инженер, техникийн ажилтнуудын тайлбарлаж байгаагаар, Харилцаа холбооны зохицуулах хорооны удирдлагаас өөрийн ажилтнуудыг томилон ажиллуулж, зарим кабелийн сувгуудын эфирийг ялгавартайгаар шууд зогсоох ажиллагаа явуулсан байна. Эрх нь зөрчигдсөн “Одод” телевиз тухайн үйлдлийг “Төрийн байгууллага хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг ноцтой зөрчсөн бүдүүлэг явдал боллоо” хэмээн үзэж Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд нарт хандан нээлттэй ил захидал илгээжээ.

Интернэт

Орчин үеийн мэдээллийн шинэ технологийн хөгжил, уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийн цахимжилт, шинэ хэвлэл мэдээллийн хурдацтай дэвшил нь интернетийн орчинд эрх зүйн зохицуулалттай болох хэрэгцээ шаардлагыг тодорхойлж байна хэмээн Монголын Засгийн газар үзэж байна. Эхний алхмын нэг нь дээр дурдсан ХХЗХ-ны тоон контентын журам юм. Энэ хүрээнд “Кибер аюулгүй байдлын тухай”, “Мэдээллийн аюулгүй байдлын тухай”, “Өгөгдөл хамгаалах тухай” хуулийн төслийн ажлын хэсгүүд Тагнуулын ерөнхий газар, Мэдээлэл, шуудан, харилцаа холбоо, технологийн газарт байгуулагджээ.

Монгол Улсын Их Хурал 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр төрийн нууцад хамаарахаас бусад мэдээ, баримт бичгийг цахим хэлбэрээр шилжүүлэх, дамжуулахтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор “Цахим гарын үсгийн тухай” хууль баталсан юм. Энэ хууль 2013 оны нэгдүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлнэ.

1.3. Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт

Хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо бий болгох талаар сүүлийн жилүүдэд өргөн хэлэлцүүлэг хийгдэж байгаа ч энэ чиглэлээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэргэжлийн эвлэл холбоод урьдын адил дорвитой алхам хийсэнгүй.

ХХЗХ-ны "Телевиз, радиогийн өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын ерөнхий нөхцөл шаардлага"-д "Телевиз, радио, кабелийн суваг нь дагаж мөрдөх мэргэжлийн ёс зүйн нэгдсэн дүрэм, түүнийг хэрэгжүүлэх ёс зүйн хороотой байх"-ыг үүрэг болгож Зохицуулах хороо үйл ажиллагаагаа тогтмолжуулахад нь дэмжлэг үзүүлнэ гэж заасан байна.

Монгол улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын "Хэвлэлийн эрх чөлөөний тухай" хуулийн шинэчилсэн найруулгын хоёр төсөлд хоёуланд нь "Хэвлэл мэдээллийн зөвлөл" байгуулахаар оруулжээ. Харин Засгийн газрын төсөлд Хэвлэл мэдээллийн зөвлөлийн "гишүүнд иргэний нийгмийн төлөөллөөс санал болгосон хүнийг Монгол улсын Ерөнхийлөгч томилно" гэсэн бол Ерөнхийлөгчийн төсөлд Зөвлөлийг нийт сэтгүүлчдийн хурлаар байгуулна" гэжээ.

ХОЁР. ХЭВЛЭЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ 2011 ОНД

2011 оны 9 дүгээр сард Азийн хүний эрх, хөгжлийн форум (FORUM-ASIA) байгууллагын төлөөлөгчид Монгол улсад ажиллаж, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаар баримт цуглуулах судалгаа хийсэн нь өнгөрсөн жилийн тэмдэглүүштэй арга хэмжээний нэг байв. Судалгааны баг тайландаа: “Уулзаж ярилцсан сэтгүүлчид нь төрийн албан хаагчид, улс төрчид, бизнесменүүд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт шахалт үзүүлэн, сүрдүүлж, тэдний эсрэг хэрэг үүсгэдэг, бие эрхтэнд нь халддаг тухай ярилаа. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд редакцийн цензур, сэтгүүлчдэд өөрийн цензур бий болоход хүргэж байна. Ийм тохиолдол гарахад хууль сахиулах байгууллагууд арга хэмжээ авдаггүй, ихэнх хэргүүд үнэн зөвөөр шийдэгдэхгүй, буруутан гэм зэмгүй өнгөрч байгаад судалгааны багийнхан түгшиж байна” гэжээ.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Нээлттэй Нийгэм Форум, Нээлттэй Нийгэм Сангийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн дэмжлэгтэйгээр 2005 оны 10 дугаар сараас сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчилд мониторинг хийж эхэлснээс хойш 2012 оны 5-р сарын нэгэн хүртэл хугацаанд нийт 220 мэргэжлийн зөрчил бүртгэгдээд байна.

Зөрчлийн тоо, хэлбэр

Зөрчлийн хэлбэр	2006	2007	2008	2009	2010	2011	Нийт
Бие эрхтэн, эрүүл мэндэд халдсан	3	3	6	-	-	1	13
Сүрдүүлсэн, дарамталсан, заналхийлсэн, доромжилсон, гэр бүлийн хүнийг дарамталсан	16	7	23	13	10	8	77
Мэдээлэл өгөхөөс татгалзсан /мэдээлэл олж авах, түгээхэд саад хийсэн	8	10	13	2	-	7	40
Ажлын багаж хэрэгсэлд халдсан	3	3	2		2	2	12
Шүүх, хүчний байгууллагын дарамт /шүүхэд нэхэмжлэл гаргасан	2	8	5	3	5	3	26
Нууц эх сурвалжаа илчлэхийг албадсан	3	1	5	1	6	3	19
Нийтлэл, нэвтрүүлэг, ХМХ-ийг хориглосон, эсвэл хориглохыг завдсан, редакцийн цензур гэх мэт бүх хэлбэрийн цензур	2	1	3	1	2	3	12
Эрүүгийн хэрэг үүсгэсэн, түр саатуулагдсан, хоригдсон	4	4	2	0	5	6	21
Нийт	41	37	59	20	30	33	220

2011 оны тавдугаар сараас 2012 оны тавдугаар сар хүртэл “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 18 сэтгүүлчийн мэргэжлийн эрхийн зөрчлийн 33 тохиолдол бүртгэжээ. Эрхийн зөрчлийнхээ талаар бидэнд мэдээлсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн байгууллагын 64% нь өдөр тутмын сонин, 26% нь телевиз, 10 хувь нь вэб сайтынх байв. Эдгээр зөрчлийн ихэнх нь буюу 63,2 % нь Улаанбаатар хотод, 36,8 % нь орон нутагт бүртгэгдсэн байна. Өнгөрсөн жилтэй харьцуулбал, орон нутгаас бидэнд хандах сэтгүүлчдийн тоо өсөх хандлагатай байна.

Сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийг зөрчигчдийн 68,5% нь эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид байв.

Дээрх тоо баримт бол зөвхөн бидэнд мэдэгдсэн зөрчлийн бүртгэл юм. Сэтгүүлчид цаашдын дарамт шахалтаас эмээн энэ талаар олон нийтэд мэдэгдэхийг хүсэхгүй байх нь олонтаа. Нөгөөтэйгүүр, олон сэтгүүлч мэргэжлийн эрхийн зөрчлийн тухай төдийлөн сайн ойлголтгүй учир өөрт нь тохиолдсон бэрхшээл хэвийн зүйл мэт ханддаг.

“Глоб Интернэшнл” төрийн байгууллага 2011 онд гарсан сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн дараахь зөрчлүүдийг онцолж байна.

ШҮҮХ, ЦАГДАА, ХҮЧНИЙ БАЙГУУЛЛАГЫН ДАРАМТ

Д.Чулуунбаатар, “Улаанбаатар таймс” сонины эрхлэгч

2011 оны гуравдугаар сарын 24-ний өдөр “Улаанбаатар таймс” сонины ерөнхий эрхлэгч Долгорын Чулуунбаатарыг цагдан хорьжээ. Түүнийг дөрөвдүгээр сарын 7-ны өдөр “2008 онд бусадтай бүлэглэн “Улаанбаатар таймс” сонин НӨҮГ-ын менежментийн гэрээний үр дүнг харгалзан хувьчилж авахдаа төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомжийг зөрчиж, НӨҮГ-ыг үрэгдүүлж, онц их хэмжээний хохирол учруулсан” хэмээн Эрүүгийн хуулийн 150-р зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгтэй холбогдуулан яллагдагчаар татсан байна.

Д.Чулуунбаатарыг цагдан хорих хугацаанд биеийн эрүүл мэндийн байдал муудаж, нарийн мэргэжлийн эмч нарын дүгнэлт гарсан байхад үүнийг үл тоомсорлох, сэтгэл санааны хувьд дарамт учруулах, эргэлт уулзалтыг цаараглах, батлан даалтад гаргах хүсэлтэд удаа дараа татгалзах зэргээр хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн явдал болсон юм.

Д.Чулуунбаатар энэ хэрэгт өөрийгөө гэм буруутай гэж үзэхгүй байгаа юм. Тэрбээр 2008 онд “Улаанбаатар таймс” сонины эрхлэгчийн ажлыг хүлээж авахад сонин өөрийн гэсэн байргүй, барилга нь хэсэгчлэн нурсан, хэдэн сая төгрөгний өртэй байснаас сонины санхүүгийн байдлыг сайжруулахын тулд маш их хүчин зүтгэл гаргаж, хөл дээр нь босгосон юм.

Тус сонины газар нь хуучнаар Д.Сүхбаатарын нэрэмжит хэвлэх үйлдвэрийн байранд байрладаг. Монголын хэвлэл мэдээллээр тус барилгыг Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр хувьчилж авсан талаар дурьддаг.

Мөрдөн байцаалтын явцад түүний ард хэн байгаа талаар байнга асуун шалгааж байсан. Нэг удаа түүнийг өмгөөлөгчгүйгээр “Таны ард хэн байгаа вэ. Тэрийгээ хэл. Та нас ахиж байгаа хүн тул хэлсэн нь дээр” гэж тулган шаардах шинжтэй байцаажээ.

Цагдаагийн байгууллагын энэ үйлдэл нь Үндсэн хууль, “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”, “Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай” хуулиудын “...өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шаардах”, “...тайлбар дүгнэлт гаргуулахаар тулган шаардах, хууль бус арга хэрэглэхийг хориглох” зэрэг заалтыг ноцтойгоор зөрчсөн явдал болсон юм.

REPORTERS WITHOUT BORDERS

FOR FREEDOM OF INFORMATION



AFRICA

AMERICAS

ASIA

EUROPE/EX-USSR

MIDDLE EAST/NORTH AFRICA

INTER

HOME PAGE - ASIA - MONGOLIA



NEWSPAPER EDITOR DOLGOR CHULUUNBAATAR FREED ON BAIL

PUBLISHED ON THURSDAY 28 JULY 2011.

Print

Send

français

Partager

7

Tweet

12

Reporters Without Borders is relieved to learn that **Dolgor Chuluunbaatar**, the editor of the daily *Ulaanbaatar Times*, was released conditionally on health grounds on 22 July. He is now in hospital receiving treatment for a serious eye infection.

He had been held since 24 March on a charge of illegally privatizing the newspaper. No date has so far been set for the trial, at which he will face the possibility of a 15-year jail sentence.

Түүнийг эмчилж байсан “Шагдарсүрэн” эмнэлэг 2011 оны дөрөвдүгээр сарын 2-ны өдөр “Нарийн мэргэжлийн эмнэлгийн газар хэвтүүлж, оношийг нарийвчлан гаргаж, эмчилгээ хийлгэхгүй бол өвчин даамжирч амь насанд аюул учруулж болох үндэслэлтэй”, дөрөвдүгээр сарын 27-ны өдөр Цагдан хорих 461 дүгээр

ангийн нэгдсэн эмнэлэг “Хоригдох хугацаанд тус эмнэлгийн дотрын тасагт нэг удаа хэвтэж эмчлүүлсэн, цаашдаа мөн “нарийн мэргэжлийн эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх шаардлагатай” тухай эрүүл мэндийн тодорхойлолт гаргасан байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага 2011 оны 5 дугаар сарын 9-ний өдөр “Өдрийн сонин”-ы Асуух эрхийн танхимд Хэвлэлийн бага хурал хийж, “Улаанбаатар таймс” сонины ерөнхий эрхлэгч, сэтгүүлч Д.Чулуунбаатарыг батлан даалтанд яаралтай гаргахыг шаардаж байгаагаа мэдэгдсэн билээ.

“Глоб Интернэшнл” ТББ Д.Чулуунбаатарыг цагдан хорих хугацаанд биеийн эрүүл мэндийн байдал нь муудаж, нарийн мэргэжлийн эмч нарын дүгнэлт гарсан байхад үл тоомсорлох, сэтгэл санааны хувьд дарамт учруулах, эргэлт уулзалтыг цаараглах, батлан даалтад гаргах хүсэлтэд удаа дараа татгалзах зэргээр хүний эрх, эрх чөлөөг зөрчиж буй үйлдлийн талаар Монгол улсын Ерөнхий прокурор, Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх Д.Дорлигжав, Нийслэлийн прокурор Б.Бат-Орших, УИХ-ын Хүний эрхийн дэд хорооны дарга, УИХ-ын гишүүн Х.Тэмүүжин, Хүний эрхийн Үндэсний комиссын дарга Ж.Бямбадорж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх Ерөнхий газрын дарга, хурандаа М.Ганхүү, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Д.Ганбат нарт хандаж мэдэгдэл хүргүүлэв.

“Глоб Интернэшнл” ТББ нь хүний эрхийн олон улсын бусад байгууллага, дэлхийн хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн хамтын нийгэмлэгээс дэмжлэг хүсэх, Д.Чулуунбаатарыг батлан даалтад гаргахыг шаардаж байгаагаа илэрхийлсэн шуурхай мэдээ түгээсний үр дүнд Олон улсын сэтгүүлчдийн холбоо, IFEX, AJA (Азийн сэтгүүлчдийн холбоо), Хил хязгааргүй сурвалжлагчид (RSF) зэрэг олон улсын байгууллагуудаас кампанит ажлыг дэмжсэн билээ. Д.Чулуунбаатарыг 2011 оны 7 дугаар сарын 22-ны өдөр батлан даалтанд гаргасан юм.

УМБГ-ын мөрдөн байцаагч, цагдаагийн хошууч Р.Отгонжаргал

2011 оны 12 дугаар сарын 17-ны өдөр ТВ-9 телевизийн уран бүтээлчид “Детектив” хэмээх нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэсэн байна. Нэвтрүүлэгт “Улаанбаатар” хэвлэх үйлдвэр, “Өргөө” зочид буудлын хувьчлалд улс төрчдөөс хэн, хэн оролцсон, ямар хууль бус явдал болсныг дүрсжүүлэн хүргэсэн ажээ.

Гэтэл 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хэвлэх үйлдвэрийн хувьчлалын хэргийг мөрдөж байсан УМБГ-ын мөрдөн байцаагч, хошууч Р.Отгонжаргал өөрийнхөө нэрийг уг нэвтрүүлэгт дурдсаныг эсэргүүцэж, Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтэст гомдол гаргажээ.

ТВ-9 телевизийн захирал Ц.Энхбат, “Детектив” нэвтрүүлгийн уран бүтээлчид болох сэтгүүлч Н.Биндэрьяа, ерөнхий продюсер Д.Төрмөнх, найруулагч Н.Баярсайхан, хөтлөгч Л.Эрдэнэбаатар нарыг гэрчээр дуудаж “Эх сурвалжаа хэл. Ямар зорилгоор нэвтрүүлэг бэлтгэсэн бэ” гэж байцаасан байна.

Өмгөөлөгч О.Баасанхүү Сүхбаатар дүүргийн прокурорт хандан, тус телевизийн сэтгүүлч, уран бүтээлчдэд эрүүгийн хэрэг үүсгэж, гэрчээр байцааж байгаа нэрийдлээр сэжигтэн яллагдагчаар татах гэж байгааг эсэргүүцжээ. Тэрээр уг хэргийн талаар, “Нэгдүгээрт мөрдөн байцаагч Р.Отгонжаргал төрийн тусгай албан хаагч. “Детектив” нэвтрүүлгээр хөндсөн асуудалд мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байгаа хүн. Тэгэхээр нэр төрд халдсан нэрээр гомдол гаргаж, хохирогч болж байгаа нь мөрдөн байцаалтын нууцыг задруулна. Үүнийг болиулаач гэсэн санаа. Хоёрдугаарт, үзэл бодлоо илэрхийлснийх нь төлөө эрүүгийн хэрэг үүсгэх нь хууль зөрчсөн үйлдэл. Өөрөөр хэлбэл, нэвтрүүлгийг бэлтгэсэн уран бүтээлчдээс гэрчийн мэдүүлэг нэрийдлээр байцаалт авч болохгүй. Харин нэвтрүүлэгт дурдагдсан эх сурвалжаас мэдүүлэг авах ёстой. Гуравдугаарт, тус телевизийн уран бүтээлчдийг сэжигтэн, яллагдагчаар татаагүй мөртлөө гэрчээр мэдүүлэг авч, тэрхүү мэдүүлэгтээ үндэслэн яллагдагчаар татах гэж байгаа нь Үндсэн хуулийг зөрчиж байна.” гэж мэдэгдлээ.

ТҮГЭЭЛТЭД УЧРУУЛСАН ДАРАМТ

Бүгд Найрамдах Намын дарга Б.Жаргалсайхан “Монголын мэдээ” сонины үйл ажиллагаанд саад хийж, олон мянган уншигчдын эрх ашгийг хөндөн, хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдалд бүдүүлгээр халдсан байна.

“Монголын мэдээ” сонины 2012 оны 4 дүгээр сарын 13-ны дугаарт БНН-ын Б.Жаргалсайхан “Долдугаар сарын 1-ний хэргийг санаатайгаар үйлдсэн болов уу гэж боддог” гэсэн гарчигтай ярилцлага өгчээ. Гэтэл улс төрд үүсээд байгаа үйл явцаас үүдэн уг ярилцлага нийтлэгдсэн сонины дугаар уншигчдын гар дээр очихоос өмнө Б.Жаргалсайхан сониныхныг болон ярилцлага авсан сэтгүүлчийг шөнөжин дарамталсаны дээр Б. Жаргалсайханы төлөөний хүмүүс “Монголын мэдээ” сонины редакцид нэвтэрч маргааш тараагдах сонин нь хэвлэгдсэн эсэхийг шалгасан, сэтгүүлчийг утсаар дарамталсан, хэвлэх үйлдвэрийн гадаа машинтай хүмүүс зогсоож ямар сониныхон сониноо авахаар ирж байгааг хянасан, шуудангийн салбаруудаас “Монголын мэдээ” сониныг худал хэлж, мөнгөөр худалдаж авсан, редакцийн нэр барьж сонины дугааруудыг эргүүлэн татсан зэрэг улс төрч хүнд баймгүй зохисгүй үйлдэл гаргажээ.



Манай сонины 2012 оны дөрөвдүгээр сарын 13-ны дугаарт улс төрийн сэтгүүлч Б.Даваагийн БНН-ын дарга Б.Жаргалсайхантай хийсэн ярилцлага нийтлэгдсэн юм. Сэтгүүлч Б.Даваа түүний хүсэлтээр ярилцлагаа өөрөөр нь хянуулсаны дараа нийтэлсэн. Манай сонин хэвлэгдэж байх үед /тэр орой/ Ерөнхийлөгч асан Н.Энхбаярыг баривчилсан бөгөөд Б.Жаргалсайхан сониныг хэвлэлтэд шилжихээс эхлээд бараг шөнийн турш манай сониныхныг янз бүрээр дарамталсан. Шалтгаан нь “Та нар Н.Энхбаярыг баривчлах гэж байгааг урьдчилж мэдчихээд надаас аль нэг нам, хүчний

захиалгаар ярилцлага авсан байна” гээд “танай сониныг хэвлүүлэхгүй, хэвлэгдсэн ч тараалгахгүй, бүгдийг нь худалдаж авна гэж дайрсан. Тэрээр “Монголын мэдээ” сониныг уншигч, захиалагчдад очихын өмнө шуудангийн 4 төвийн хоёр уруу нь хүчээр орж, захиалагчдад хүрэх сонинг булааж /худалдаж/ авсан. Энэ бусармаг үйлдлийн дараа бид тэр даруй хэвлэлийн бага хурал зарлан, хэвлэлийнхэнд мэдээлж сэрэмжлүүлсэн юм. Мөн Монголын сэтгүүлчдийн эвлэл, “Глоб Интернешнл” ТББ-д хандахад сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрхийг хамгаалахаа илэрхийлж Хамтарсан мэдэгдэл гаргасан. Мөн МСЭ-ийн ерөнхийлөгч Б.Галаарид энэ үйл явдалтай холбогдуулан манай редакцид ирж, сэтгүүлчидтэй санал бодлоо солилцож биднийг дэмжихээ илэрхийлсэн.

Хэвлэл, мэдээлэл, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хөхиүлэн дэмжигч олон улсын байгууллагууд БНН-ын дарга Б.Жаргалсайхан “Монголын мэдээ” сонины үйл ажиллагаанд бүдүүлгээр халдсан явдлыг буруушаан, эсэргүүцлээ илэрхийлсээр байна.

Дэлхийн 131 орны 600 000 сэтгүүлчдийг эгнээндээ нэгтгэсэн Олон улсын сэтгүүлчдийн холбоо (ОУСХ) болсон явдалд санаа зовниж буйгаа илэрхийлэн, мэдэгдэл гарсан. Олон Улсын сэтгүүлчдийн холбооны Ази Номхон далайн бүсийн захирал Жаклин Парк “Монголд олон нийтийн ашиг сонирхолд нийцсэн мэдээ, мэдээллийг түгээхэд саад хийсэн нь хэвлэлийн эрх чөлөөнд халдсан явдал бөгөөд араасаа айдас хүйдэс дагуулж байна. Улс төрчид, улс төрийн нам эвслүүд нь хэвлэл мэдээллийн хараат бус байдалд хөндлөнгөөс оролцох, тэдний мэдээ мэдээлэлд нөлөөлөх оролдлого нь байж болшгүй зүйл юм” гэсэн байна.

Мөн Канадын Торонто хотод төвтэй Олон Улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ /International Freedom of Expression Exchange/ байгууллага нь гишүүн орнууддаа /тус байгууллага 90 гишүүнтэй/ болсон хэрэг явдлын талаар шуурхай мэдээ түгээсэн байна. Тус байгууллагын гишүүн Пакистаны хэвлэлийн сангаас түүний Ерөнхий нарийн бичгийн дарга Овайс Ислам Алигийн гарын үсэгтэй Б.Жаргалсайханы үйлдлийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлэн, шаардлагатай үед тусалж дэмжихээ мэдэгдэж албан захидал ирүүлээ.

Бид Б.Жаргалсайханыг манай уншигчдаас уучлал гуйхыг шаардсан боловч одоогоор ямар нэг хариу ирүүлээгүй байна. Бид Б.Жаргалсайханд уншигч захиалагчдын хохирлыг барагдуулахыг шаардсан албан бичиг хүргүүлнэ. Хэрэв буруугаа хүлээж, хариу үйлдэл үзүүлэхгүй бол бид хууль хяналтын байгууллагад хандаж, асуудлыг шийдүүлэх болно.

“Монголын мэдээ” сонины ерөнхий эрхлэгч С.Гантоогоо

“Глоб Интернэшнл” ТББ Б.Жаргалсайханы энэ үйлдлийг хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн мэдээлэл авах язгуур эрхэнд халдсан явдал төдийгүй Монгол улсын Эрүүгийн хуулийн “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн ... ” гэсэн 139 дүгээр зүйлийг зөрчсөн ноцтой үйлдэл боллоо хэмээн үзэж байна.

ХУВИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАРАМТ

2012 оны нэгдүгээр сарын 3-ны өдөр “Хонгор” телевизийн сэтгүүлч Т.Данаасүрэн, зураглаач Ж.Түвшинтулга нар “Спейшл майнз” ХХК хувиараа ашигт малтмал олборлогчдыг эрх мэдлээрээ дарангуйлж байгаа талаар иргэдийн мэдээллийн мөрөөр газар дээрээс нь сурвалжлахаар Баян-Овоо сумын нутаг “Цагаан цахир” хэмээх алтны үндсэн чулуун ордны газар очсон байна.



Орон нутагт сэтгүүлчдийн мэргэжлийн эрхийн зөрчил алхам тутамд тохиолддог. Сэтгүүлчдийг улс төрийн нүдээр харж ялгаварлах, мэдээллийн эх сурвалжаа илчлэхийг шаардах зэрэг зөрчлүүд байсаар байна. Бие даан үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн хэрэгсэл дарамтанд орж, санхүүгийн хараат байдалтай болж байна. Үүнээс үүдэн хөдөө орон нутагт мэргэжилтэй боловсон хүчин дутагдаж байна. Манай аймагт Иргэдийн хурлын дэргэд төрийн өмчит телевиз хууль зөрчин үйл ажиллагаа явуулдаг.

Бид иргэдийн мэдээллийн мөрөөр аймгийн нэгдсэн эмнэлгийн дотрын тасгийн ариун цэврийн талаар сурвалжлага хийж, иргэдэд хүргэсэн билээ. Удалгүй тус эмнэлгийн эмч, сувилагч нар ажлын байран дээр ирж, хэл амаар доромжлон, мэдээлэл өгсөн иргэдийн утасны дугаарыг нэхэж, утсан дээр хадгалагдсан дугааруудыг тэмдэглэж авсан явдал гарсан.

Би 2012 оны нэгдүгээр сарын 3-ны өдөр зураглаач Ж.Түвшинтулгын хамт иргэдийн мэдээллийн дагуу “Спейшл майнз” ХХК-ний хувиараа ашигт малтмал олборлогчдыг эрх мэдлээрээ дарангуйлж байгаа талаар сурвалжлахаар явсан юм. Тус компаний ажилтнууд малчин Түвшинг боомилон унагаасан талаар газар дээрээс нь сурвалжилчихаад, “Спейшл майнз” ХХК-ны холбогдох ажилтнуудаас тодруулга авахаар очиход харуул хамгаалалтын ажилтнууд нь бидний эрхэнд маш бүдүүлгээр халдсан.

“Спейшл майнз” ХХК-ний хамгаалалтын ажилтнуудын үйлдлийг хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн мэдээлэл авах эрхэнд халдсан төдийгүй Монгол улсын Эрүүгийн хуулийн 139-р зүйлийг зөрчсөн ноцтой үйлдэл болсон гэж бид үзэж байна.

Бид аймгийн сэтгүүлчдийн салбар зөвлөлд эрхээ хамгаалуулахаар хандсан боловч өнөө хүртэл асуудал шийдэхгүй 4 сар болж байна. Хэвлэл мэдээллийн ажилтнуудыг сүрдүүлэх, эрхэнд нь халдах явдал нэмэгдсээр байгаа энэ үед орон нутагт бидний эрхийг хамгаалах мэргэшсэн өмгөөлөгч дутагдалтай байна.

Т.Данаасүрэн

“Хонгор” телевизийн сэтгүүлч, Баянхонгор аймаг

“Хонгор” телевизийнхэн тэнцвэртэй мэдээлэл хүргэх зорилгоор “Спейшл майнз” ХХК-ны холбогдох ажилтнуудаас тодруулга авахаар очиход харуул хамгаалалтын ажилтнууд нь хэл амаар доромжлон, бороохойгоороо чичилж, камерыг нь булаан гэрэл, чихэвчийг нь эвдэлжээ. Түүгээр зогсохгүй тэднийг хүйтэн гэрт хоёр цаг гаруй саатуулан, хэл амаар үргэлжлүүлэн доромжилж, камерт байсан бичлэгийг нь устгажээ.

“Глоб Интернэшнл” ТББ нь “Спейшл майнз” ХХК-ний хамгаалалтын ажилтнуудын үйлдлийг хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн мэдээлэл авах эрхэнд халдсан төдийгүй Монгол улсын Эрүүгийн хуулийн “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн ...” гэсэн 139-р зүйлийг зөрчсөн ноцтой үйлдэл гэж үзэж байна.

ШАШНЫ БАЙГУУЛЛАГЫН ДАРАМТ

“ТВ-8” телевизийн сэтгүүлч Ж.Минжин “Бурханы сүм дэлхийн сайн мэдээний авралын зар” нийгэмлэгт (“World Mission Society Church of God”) гишүүн байсан хүмүүсийн мэдээлэл, мөн тодорхой эх сурвалжууд дээр үндэслэн тус нийгэмлэгийн талаар мэдээ бэлтгэн 2011 оны 9 дүгээр сарын 6-ны өдрийн 20.00 цагийн мэдээний хөтөлбөрөөр нэвтрүүлжээ.

Сэтгүүлч Ж.Минжин тус сүмийн “дэлхий 2012 онд сөнөнө” гэсэн зөгнөлийн талаар тодруулах зорилгоор асуудал дэвшүүлсэн мэдээ бэлдсэн бөгөөд мэдээг тэнцвэртэй байдлаар хүргэх зорилгоор “Бурханы сүм дэлхийн сайн мэдээний авралын зар” нийгэмлэгийн солонгос эзнээс 2012 онд болох зөгнөлийн талаар номлодог эсэх талаар асуухад тэрээр үгүйсгэсэн хариулт өгсөн байна. Сэтгүүлч мэдээгээ тус сүмийн дэргэд байрлах сургуулийн хажуугаас “Бид бусдын шашин шүтэх, эс шүтэх эрхэд нь халдах гээгүй, сөрөг үйл ажиллагаа хийх гэсэнгүй. Бид сүмийн итгэгчдээс тодруулга авах зөвшөөрөл асуухад л бүгд сандралдаж эхэлсэн. Гэхдээ Монгол улсын иргэн хэн боловч сэтгэл зүй, бие махбодь, санхүүгээрээ хохирох вий, бусдадаа сөрөг нөлөө үзүүлэх вий гэдэг асуудал бидэнд хамаатай юм. Тиймээс энэ мэдээг зөвхөн асуудал дэвшүүлэн бусдын болоод хэн нэгний эрхэнд халдалгүй бэлтгэлээ” гэсэн тайлбартайгаар нэвтрүүлжээ.

Уг мэдээний дараа сүмээс телевизийн удирдах албан тушаалтнаар дамжуулан мэдээний бичлэгийг устгуулсан байна. Үүний дараа сүмийн солонгос эзэн, том биетэй монгол залуугийн хамт “ТВ-8” телевизийн байранд ирж, монгол залуу нь сэтгүүлч Минжинг “Чамайг ална. Танай муусайн хэдэн сэтгүүлчийг ахиж ганц үг дуугарахгүй болгоод өгч чадна шүү. Удахгүй чамайг хорлоно. Харж байгаарай” хэмээн заналхийлж байгаад явжээ. Удалгүй тус сүмийн итгэгч эрэгтэй эмэгтэй хүмүүс сэтгүүлч рүү удаа дараа өдөр шөнөгүй утасдан, сүрдүүлж, “ална, хараана, чи үхлийн уяанаас барьсан” гэж айлган, сэтгэл санааны хүнд дарамтанд оруулсан байна.

“Бурханы сүм дэлхийн сайн мэдээний авралын зар” нийгэмлэг нь 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр Чингэлтэй дүүргийн шүүхэд нэхэмжлэл гаргажээ. Нэхэмжлэлдээ “Бодит байдалд нийцэхгүй мэдээлэл нийтэд тараасан, нийгэмлэг болон итгэгч бидний хуулиар олгогдсон шашин шүтэх, эс шүтэх эрхэнд халдаж, нэр төр, алдар хүнд, сэтгэл санааны болон ажил хэргийн нэр хүндэд хохирол учирсан” гэж дурьдаад “ТВ-8” телевизээс “Бурханы сүм дэлхийн сайн мэдээний авралын зар” нийгэмлэг, итгэгчдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийн хохиролд

30 сая төгрөг, эдийн хохиролд 172,000 төгрөг гаргуулах, “ТВ-8” телевизээр тус нийгэмлэгийн болон итгэгчдийн нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээнд няцаалт буюу залруулга хийх, “ТВ-8” телевиз болон сэтгүүлч Ж.Минжинг телевизээр тус нийгэмлэг болон итгэгчдээс уучлал гуйх шаардлага тавьжээ.

ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЭСРЭГ ИРГЭНИЙ БОЛОН ЭРҮҮГИЙН ХЭРЭГ

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Монгол улсын хэмжээнд 2010, 2011 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан иргэний хэрэг, маргаан, бусдыг гүтгэсэн, доромжилсон эрүүгийн хэргүүдийг шүүхээр эцэслэн шийдвэрлэсэн байдлыг судлан, Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг эрх мэдэлтэн, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллага хэрхэн ашиглаж буйд судалгаа хийсэн юм.

Монгол улсын Иргэний хуулийн 21, 27, 497, 511 дүгээр зүйлүүдэд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалах, учирсан гэм хорын хохирлыг арилгах, Эрүүгийн хуулийн 110 дугаар зүйлд доромжлох, 111 дүгээр зүйлд гүтгэх үйлдлүүдийг гэмт хэрэгт тооцохоор тус тус зохицуулсан байдаг.

Судалгааг дараах мэдээлэлд үндэслэв. Үүнд:

- Нийслэлийн шүүхийн архивт буй есөн дүүргийн шүүхийн баримт бичгүүдтэй танилцан дэлгэрэнгүй жагсаалт гаргав.
- Дурьдсан хугацаанд шийдвэрлэсэн хэргийн талаар судалгаа ирүүлэхийг хүссэн албан бичгийн дагуу 21 аймгийн шүүхээс ирүүлсэн судалгааны мэдээлэл

Монгол Улсын хэмжээнд 2010 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд гутаасан гэх иргэний 67, гүтгэлэг доромжлолтой холбоотой эрүүгийн 2 хэрэг, 2011 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан 43 хэрэг, гүтгэх доромжлохтой холбоотой эрүүгийн 7 хэрэг бүх шатны шүүх, прокурорын байгууллагаар хянан шийдвэрлэгджээ.

Эдгээрээс 2010 онд шийдвэрлэгдсэн иргэний 37 хэрэг, 2011 онд шийдвэрлэгдсэн иргэний 23 хэрэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл бусдын нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан хэмээн хариуцагчаар татагдсан байна. 2010 онд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй бол 2011 онд эрүүгийн 3 хэрэгт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл холбогджээ.

Нутаг дэвсгэрийн байдлаар нь авч үзвэл Улаанбаатар хотод 2010 онд иргэний 35 хэрэг, 2011 онд иргэний 21 хэрэг, орон нутагт 2010, 2011 онд иргэний тус бүр хоёр хэрэгт Дорнод аймгийн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хариуцагчаар татагджээ. 2011 онд шүүхээр шийдвэрлэгдсэн эрүүгийн гурван хэрэг Улаанбаатар хотын сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн эсрэг байсан бол дурьдсан онуудад орон нутагт сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд холбогдох эрүүгийн хэрэг шийдвэрлэгдээгүй байна.

2010 онд нэхэмжлэгчдийн 69,7 хувь нь эрх мэдэлтэн, төрийн өндөр албан тушаалтан, төрийн албан хаагчид, төрийн өндөр алба хашиж байсан хүмүүс, 21,2 хувь нь бизнесмэн, хувийн компаниуд байна. 2011 онд нийт нэхэмжлэл гаргагчдын 22,2 хувь нь төрийн өндөр албан тушаалтнууд, 40,7 хувь нь бизнесмэн, банк, санхүүгийн байгууллага, хувийн компаниуд байна.

1999-2011 онд нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой шүүхээр шийдвэрлэгдсэн 533 хэргийн 58,7 хувь нь сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг хэрэг байна.

Нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхээр сэтгүүлч, хэвлэл мэдээллийн эсрэг нэхэмжлэл гаргасан төрийн өндөр албан тушаалтнууд 2010 онд 200 сая төгрөг, 2011 онд 30 сая төгрөг нэхэмжилсэн бол бизнесийн байгууллагаас нэхэмжилсэн мөнгөн шаардлагын дээд хэмжээ 2010 онд 900 сая, 2011 онд 200 сая төгрөг хүрчээ.

2010 онд шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн 86,5, 2011 онд 84,6 хувьд шүүх сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл буруутай гэсэн шийдвэр гаргасан, талууд эвлэрсэн тохиолдол байна.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслээс нэхэмжилж байгаа мөнгөн шаардлагын хэмжээ өсч, ялагдсан сэтгүүлч, хэвлэл мэдээллийн тоо буурахгүй байгаа нь төрийн өндөр албан тушаалтан, бизнесийн байгууллагууд Иргэний болон Эрүүгийн хуулийн зохих зүйл заалтыг сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх хэрэгсэл болгон ашиглаж байна гэж дүгнэж болохоор байна.

Өмнөх онуудын хэргүүдтэй харьцуулсан үзүүлэлт

Он	Иргэний хэрэг		Эрүүгийн хэрэг	
	Нийт хэрэг	ХМХ-д хамаарах	Нийтхэрэг	ХМХ-дхамаарах
1999	30	-	3	-
2000	39	-	-	-
2001	31	11	4	-
2002	44	37	2	2
2003	28	18	1	1
2004	40	40	1	1
2005	29	25	1	1
2006	36	31	3	3
2007	33	33	-	-
2008	39	25	5	5
2009	44	17	1	-
2010	67	37	2	-
2011	43	23	7	3
Бүгд	503	297	30	16

Монголд чөлөөт, хараат бус хэвлэлийн тогтолцоо бий болсноос хойш хорь гаруй жил өнгөрлөө. Энэ хугацаанд хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулахын тулд эрх зүйн шинэ шинэ зохицуулалт бий болжээ. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн тоо, ялангуяа сүүлийн жилүүдэд телевиз, цахим хэвлэл мэдээллийн тоо нэмэгдэж, нийгэмд олон

ургальч үзлийг хөхиүлэн дэмжихэд чухал үүрэг гүйцэтгэх болов. Гэсэн хэдий ч олон түмний үнэнийг мэдэх эрх, сэтгүүлчдийн тэдэнд үнэнийг хэлэх эрх нь байнга зөрчигдөж байна. Үнэнийг хэлэхийн тулд сэтгүүлчид хараат бус байх ёстой. Хараат бус байдал бол сэтгүүл зүйн үнэт зүйл юм. Гэтэл аливаа дарамт шахалтгүйгээр үнэнийг хэлэх боломж сэтгүүлчдэд тэр бүр олдохгүй байна. Учир нь хэвлэл мэдээллийн редакци нь улс төр, эдийн засгийн хувьд хараат бус байж чадахгүй байгаа нь иргэдэд чанартай мэдээлэл түгээхэд саад тотгор болсон хэвээр байна.

1991 онд ЮНЕСКО, Олон улсын сэтгүүлчдийн холбооноос хамтран баталсан Виндхукийн зарчимд “Хараат бус хэвлэл гэж засгийн газар, улс төр, эдийн засгийн хяналт, мөн материал, үйлдвэрлэл, түгээлтийн дэд бүтцээс хараат бус байхыг хэлнэ” гэсэн билээ.

Нөгөөтэйгүүр, Монголд өнөө хэр нь хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын тогтолцоо үгүй, хэвлэл мэдээллийн удирдлагууд ийм байгууллагыг хамтран байгуулах хүсэл зорилго үгүй, сэтгүүлч бүр чандлан дагаж мөрдөх ёс зүйн нийтлэг зарчим үгүй байгаа нь мэргэжлийн сэтгүүл зүйг үнэгүйдүүлэхэд хүргэж, “төлбөрт, “захиалгат” сэтгүүл зүй цэцэглэн хөгжихөд нөлөөлж байна.

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийнхэн мэргэжлийнхээ нэрийг эрхэмлэн дээдлэхгүй, улс төр, бизнесийн бүлэглэлийн эрх ашигт үйлчилсээр байвал хэвлэл мэдээлэл олон нийтийн “хоточ нохой”-н үүргээ умартахад хүрч, олон нийтийн итгэл найдварыг алдах болно.

Иймд Монголын сэтгүүлч, хэвлэл мэдээллийн удирдлага, мэргэжилтнүүд нийтлэг үнэт зүйл, эрх ашгаа хамгаалахын төлөө дуу хоолойгоо нэгтгэх нь чухал юм.

Хэвлэлийн эрх чөлөө бол эрх баригчдын бэлэг бус, түүнийг тэмцэж олдог.

ХАВСРАЛТ 1

ОЛОН УЛСЫН БАРИМТ ЦУГЛУУЛАХ СУДАЛГАА

Азийн хүний эрх, хөгжлийн форум (FORUM-ASIA) нь Монгол улсад үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх, эрх чөлөөний байдалд дүгнэлт хийх зорилгоор Олон улсын баримт цуглуулах судалгааг 2011 оны 8-р сарын 28-наас 9-р сарын 2-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэв.

Баримт цуглуулах судалгааг FORUM-ASIA байгууллагын гүйцэтгэх захирал Яп Свисен, БНСУ-ын Хунгик Их сургуулийн хуулийн тэнхимийн профессор Хи Кыон Чо нарын хүний эрхийн мэргэжилтнүүд явуулав. Эдгээр хүмүүс Улаанбаатар хотноо Ерөнхийлөгчийн Тамгын газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, хэвлэл мэдээллийн байгууллагууд, сэтгүүлчид, төрийн бус байгууллага, Хүний эрхийн үндэсний комиссын төлөөлөлтэй уулзан, Дархан, Эрдэнэт, Булган хотуудад судалгаа хийлээ.

Баримт цуглуулах судалгааны багийнхан 2011 оны 6-р сард “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хууль шинээр батлагдсаныг эерэг алхам боллоо хэмээн сайшааж байна. Гэсэн ч, ардчилалд шилжээд удаагүй байгаа орны хувьд, Засгийн газарт хандаж тавих олон асуудал байгааг онцолж байна.

Баримт цуглуулах судалгааны багийнхан урьдчилсан тайландаа “Сэтгүүлчдийн эсрэг гүтгэлэг, доромжлолтой холбоотой хэргүүд, ялангуяа эрүүгийн хэрэг өсөх хандлагатай байгаад түгшиж байна. Эдгээр хэргүүдийн дотор төрийн албан тушаалтнууд сэтгүүлчдийн эсрэг эрүүгийн хэрэг үүсгэж байгаа нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөнд асар их сөрөг нөлөө үзүүлдэг.

Ардчилсан нийгэмд төрийн өндөр албан тушаалтнууд нийгмийн өмнө хариуцлага хүлээдэг ба түмний хараа хяналт, шүүмжлэлд өртөмтгий бүлэгт багтдаг юм. Төрийн алба хашиж байгаагийн хувьд шүүмжлэлд өртсөн бол тэд гомдол гаргах ёсгүй байдаг.

Гүтгэлэг, доромжлолын хэргийг шийдвэрлэх олон арга байдаг. Үүнд: эвлэрэх, залруулга нийтлэх, олон нийтийн өмнө уучлал хүсэх, иргэний хэргээр шийдвэрлэх гэх мэт. Хэвлэл мэдээлэл нь нийгмийн “хоточ нохой” бөгөөд хэвлэлийн эрх чөлөө бол эрүүл саруул ардчилсан нийгмийн тулгын чулуу юм. Иймээс, гүтгэлэг доромжлолын заалтыг олон улсын хүний эрхийн хэм хэмжээнд нийцүүлэн, үзэл бодлоо илэрхийлэх эрх, эрх чөлөө, хэвлэлийн эрх чөлөөнд сөрөг нөлөө үзүүлэхгүйн тулд эрүүгийн хуулиар шийдэхгүй байх шаардлагатай.

Судалгааны багийнхан Монгол улсад сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалсан хууль эрх зүйн орчин байхгүйгээс сэтгүүлчид шүүх, цагдаагийн байгууллагаас эх сурвалжаа илчлэх дарамт, албадлагад өртдөг. Шүүх цагдаагийн байгууллага нийтлэлд дурьдагдаж шүүмжлүүлсэн хүмүүсийг шалгах, үнэн мөнийг олохын оронд түүнийг илчилсэн сэтгүүлчийг шалгадаг нь түгшээж байна.

Төрөөс хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд нийтлэх мэдээлэлд цензур тавихгүй гэсэн заалт бүхий 1998 онд батлагдсан “Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай” хууль байсаар атал, мэдээ, нийтлэлийн агуулгыг цагдан хянах явдал түгээмэл гардгийг багийн гишүүд тэмдэглэж байна. Уулзаж ярилцсан сэтгүүлчид төрийн албан хаагчид, улс төрчид, бизнесменүүд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дарамт шахалт үзүүлэн, сүрдүүлж, тэдний эсрэг хэрэг үүсгэдэг, бие эрхтэнд нь халддаг тухай ярилаа. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлд редакцийн цензур, сэтгүүлчдэд өөрийн цензур бий болоход хүргэж байна.

Сэтгүүлчдийн бие эрхтэнд халдах, тэднийг сүрдүүлэх, дарамтлах тохиолдол гарахад хууль сахиулах байгууллагууд арга хэмжээ авдаггүйг судалгааны багийнхан онцлон тэмдэглэж байна. Ихэнх хэргүүд үнэн зөвөөр шийдэгддэггүй бөгөөд буруутан гэм зэмгүй өнгөрдөг. Сэтгүүлч Ю.Гэрэлтуяагийн хальсандаа буулгаж авсан “Бид өөрсдөө өгч байсан учраас мэдэлгүй яах вэ. Хэнд авлига өгч байснаа нэрлэ гэвэл нэрлэнэ. Авлига авч байсан нөхдүүдтэйгээ зэрэгцээд сууж байна” гэсэн ярилцлага өгсөн Их хурлын гишүүн албан үүргээ гүйцэтгэсээр байна.

Төрийн байгууллага, албан тушаалтнуудаас мэдээлэл авах нь ихэнх сэтгүүлчдэд хүндрэлтэй хэвээр байна. Сэтгүүлчдэд мэдээлэл өгөхөөс татгалзахдаа тэд төрийн нууц гэсэн үгээр халхавч хийдэг.

Монгол улсад хэвлэл мэдээллийн өмчлөл ил тод бус байна.

Хэвлэл мэдээлэл улс төрд чухал үүрэгтэй ба сонгуулийн үеэр энэ үүрэг нэмэгддэг. Ихэнх улс төрчид шууд болон шууд бусаар ямар нэгэн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эзэмшдэг болохыг судалгааны багийнханд мэдээлэв. Байдал ийм байхад, олон нийт бодит үнэн ба улс төрийн ухуулга хоёрыг ялгаж салгахад төвөгтэй бөгөөд хэвлэл мэдээллийн хэрэгсэл нийгмийн “хоточ нохой” байх үүргээ биелүүлж чадахгүйд хүрэх юм.

Монгол улсын харьцангуй цөөн 3 сая гаруй хүн амд 400 гаруй хэвлэл мэдээллийн хэрэгсэл үзэл бодол илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн эрх чөлөөг хэрэгжүүлэх үйлсэд хүчин зүтгэж байна. Тухайлбал, 80,000 гаруй хүн амтай Эрдэнэт хотод 8 телевиз, 5 радио, 3 сонин үйл ажиллагаа явуулж байна. Жижиг зах зээл дэх ширүүн өрсөлдөөн нь хэвлэл мэдээллийн өмчлөгчид, сэтгүүлчдийн орлогыг бууруулдаг. Зарим сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд орлогын бусад эх үүсвэр хайхаас өөр аргагүйд хүрдэг. Тэд төлбөртэй материал нийтэлдэг нь нууц биш юм.

Монголын Засгийн газар шинэ залуу ардчиллаа бэхжүүлэхийн тулд сэтгүүлчдийг хамгаалсан хууль эрх зүйн орчин бүрдүүлэх шаардлагатай байна.

Олон улсын баримт цуглуулах судалгааны багийнхан Монголын Засгийн газарт дараах зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. Гүтгэлэг доромжлолтой холбоотой 110, 111 дүгээр заалтуудыг Эрүүгийн хуулиас хасах.
2. Мэдээллийн нууц эх сурвалжийг хамгаалах эрх зүйн орчин бүрдүүлэх
3. Хэвлэл мэдээллийн өмчлөлийг олон нийтэд ил тод болгох
4. Төлбөртэй, захиалгат мэдээ, нийтлэлийг ил тод зарлах
5. Төрийн нууцын хуулийг эргэн харж, төрийн нууцад хамаарах асуудлыг нарийвчлан, тодорхой болгох
6. Төрийн албанд олон нийтийн гомдол саналыг хүлээн авч, шийдвэрлэж байх эрх бүхий Омбудсмен байгуулах
7. Хэвлэл мэдээлэлд чиглэсэн олон нийтийн санал гомдлыг хүлээн авах хараат бус Хэвлэлийн Консул бий болгох, хэвлэл мэдээллийн ажилтнуудыг ёс зүйн дүрмээ сахиx, сэтгүүлчдийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх
8. “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” хуулийг олон нийтэд өргөнөөр таниулах, төрийн албан хаагчдад, ялангуяа орон нутгийн удирдлагуудад хуулийн талаар сургалт явуулах
9. Төрийн албан хаагчдад ардчилал, хүний эрх, хэвлэл мэдээллийн эрх, үүргийн талаар таниулж, сургалт явуулах.
10. Сэтгүүл зүйн коллеж, их, дээд сургуулиудын сургалтын чанарт анхаарах

СЭТГҮҮЛЧДЭД ЗОРИУЛСАН ӨӨРӨӨ ШУУРХАЙ МЭДЭЭЛЭХ СИСТЕМ

“Глоб Интернэшнл” ТББ нь 2010 оны сүүлээс өөрөө шуурхай мэдээлэх (self-alerting) мониторингийн шинэ систем нэвтрүүлснээр сэтгүүлчид хэн нэгнээр дамжуулах бус өөрөө өөрийнхөө тухай, мэргэжлийн үүргээ гүйцэтгэхэд нь тохиолдож буй бэрхшээлийнхээ талаар цаг алдалгүй, хэн нэгнээр дамжуулалгүй, шуурхай мэдээлэх боломжтой болсон билээ.

Сэтгүүлч нь Өөрөө шуурхай мэдээлэх (self-alerting) мониторингийн онлайн шинэ системээр

www.globeinter.org.mn/selfalerting

асуулга бөглөн олон нийтэд нээлттэй эсхүл хаалттай мэдэгдэх эсэхээ сонгон илгээнэ. Эрхийн зөрчлийнхөө асуулгыг үнэн зөв бөглөсний дараа Глобоос ямар тусалцаа, үйлдэл хийхийг хүсч буйгаа сонгоно. Үүнд:

- Санал бодлоо солилцох
- Эрх зүйн зөвлөгөө авах
- Сүлжээгээр түгээх
- Эрхийг нь зөрчсөн албан тушаалтанд эсэргүүцлийн захидал илгээх
- Хэвлэлийн бага хурал зарлан олон нийтэд мэдэгдэх

Онлайн систем ашиглах боломжгүй сэтгүүлчид дараах аргаар бидэнтэй холбогдох боломжтой. Үүнд:

- Yahoo messenger: alert_mon
- Гар утас: 99127127, 99193327
- Суурин утас: 324764, 324627
- Факс: 315326
- Өөрийн биеэр байгууллага дээр ирэх: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Дипломат 95 цогцолбор, 6-р орц, 70 тоот.
- Имэйл: globe@globeinter.org.mn; globenews@globeinter.org.mn; globemon@gmail.com

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн талаар шуурхай мэдээ хүлээн авч, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд, үндэсний сүлжээ, олон улсын сүлжээгээр, тухайлбал Олон улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ (IFEX), Олон улсын сэтгүүлчдийн холбоо (IFJ), Эрх чөлөөний ордон (Freedom House), Хил хязгааргүй сурвалжлагчид (Reporters Without Borders), Forum Asia, GFMD, Internews International, “XIX зүйл” (Article XIX) зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг дэмжигч олон улсын байгууллагууд, НҮБ-ын Хүний эрхийн комисс, Дэлхийн банк болон Гадаадын элчин сайдын яамд, Монгол улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудад дараах хэлбэрээр түгээж байна:

- “Глоб Интернэшнл” ТББ-ын цахим хуудас www.globeinter.org.mn
- “Глоб Интернэшнл” ТББ-ын вэбд суурилсан имэйл маркетингийн программ хангамж ашиглан зорилтот 5000 хэрэглэгчдэд
- “Глобын мэдээ” 2 сар тутмын онлайн сонин
- Хэвлэлийн бага хурал
- Хэвлэлийн эрх чөлөөний тайлан
- Фейсбүүк